



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар АНЮМ

Арвайхээр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1, 34.2, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Ногоон бүс" төслийн жишигт нийцүүлэн Арвайхээр сумын 5, 13 дугаар багуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 83 ширхэг чиглэлийн камер худалдан авах асуудлаар ажлын даалгавар боловсруулж, санал, дүгнэлт гаргаж 2023 оны 6 дугаар сарын 27-ны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0786

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 07-ны өдрийн 08/07 дугаар  
захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Гишүүд:

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Б.Анхтуяа (Төрийн үйлчилгээ мэдээллийн төвийн  
дарга)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Батпүрэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Цагдаагийн газрын Нийтийн  
хэв журам сахиулах тасгийн дарга Цагдаагийн  
хошууч)

С.Мөнхзаяа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр,  
зураг төсөл, магадалын асуудал хариуцсан  
мэргэжилтэн)

М.Багаажав (ЭБЦТС ТӨХК-ийн Өвөрхангайн  
салбарын Ерөнхий инженер)

Б.Баасансүрэн (Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-  
ийн Өвөрхангай аймгийн газрын Кабель шугам  
сүлжээний инженер)

Нарийн бичгийн дарга: М.Эрдэнэболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтэн)